

Улсын бүртгэлийн дугаар..
Аравтын бүрэн
Ангиллын код

Нууцын зэрэглэл Б
Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар
Шу Гх/ОХУ/-2019/10

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

**“1921 ОНЫ МОНГОЛЫН ХУВЬСГАЛЫГ
МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТҮҮХИЙН
ҮҮДНЭЭС ХАРАХ НЬ”
(1921 оны Монголын хувьсгалын
100 жилийн ойд зориулав)**

Монгол, Оросын хамтарсан төслийн тайлан
(2019-2022 он)

Төслийн удирдагч: Н.Хишигт- Ойрх үеийн түүхийн судалгааны
салбарынЭрдэм шинжилгээний тэргүүлэх
ажилтан,доктор (Ph.D), профессор

Захиалагч байгууллага: Боловсрол, шинжлэх ухааны яам

УЛААНБААТАР
2023

Улсын бүртгэлийн дугаар
Аравтын бүрэн
Ангиллын код

Нууцын зэрэглэл Б
Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар
Шу Гх/ОХУ/-2019/10

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

**“1921 ОНЫ МОНГОЛЫН ХУВЬСГАЛЫГ
МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТҮҮХИЙН ҮҮДНЭЭС ХАРАХ НЬ”
(1921 оны Монголын хувьсгалын 100 жилийн ойд зориулав)**

Монгол, Оросын хамтарсан төслийн тайлан
(2019-2022 он)

Төслийн удирдагч:	Н.Хишигт- Ойрх үеийн түүхийн судалгааны салбарынЭШТА,доктор (Ph.D), профессор
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан технологийн сан
Захиалагч байгууллага:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Гүйцэтгэгч байгууллага : утас, цахим шуудан:	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн Монгол улс, 13330.Улаанбаатар хот, БЗД,13-р хороо, Энхтайваны өргөн чөлөө Утас:11-458305, Цахим шуудан:history@mas.ac.mn

УЛААНБААТАР
2023

ГАРЧИГ

Гүйцэтгэгчдийн нэрийн жагсаалт.....	4
Товчилсон үгийн жагсаалт.....	5
Хураангуй түлхүүр үг.....	6
Тайлангийн удиртгал.....	7-9
Тайлангийн үндсэн хэсэг.....	10-23

ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

1. Чагдарсүмбэрэлийн Батдорж. Ойрхи үеийн түүхийн салбарын ЭША, (Ph.D).
(Ном зүйн бүтээл, Баримт бичгийн эмхэтгэл, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Эрдэм шинжилгээний илтгэл 1)

2. Норовсамбуугийн Наранжаргал. Улаанбаатарын их сургуулийн докторант
(Ном зүйн бүтээл, Баримт бичгийн эмхэтгэл, Эрдэм шинжилгээний илтгэл 1, диссертаци 1).

3. Норовсамбуугийн Хишигт, Ойрхи үеийн түүхийн салбарын ЭШТА, (Ph.D), проф. (Хамтын бүтээлийн зохиогч, Номзүйн бүтээл, Баримт бичгийн эмхэтгэл, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Эрдэм шинжилгээний өгүүлэл 5, илтгэл 3)

4. Шаравын Эрдэнэбат. Монгол улсын Үндэсний Төв архивын Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын Баримтын архивын судлаач. Магистр

(Баримт бичгийн эмхэтгэлийн эмхэтгэгч)

ТОВЧИЛСОН ҮГ

АВП РФ- Архив Внешней политики Российской Федерации
АДБНУ -Алс Дорнотын Бүгд Найрамдах улс
АДНБДНГ- Алс Дорнотын Нарийн бичгийн дарга нарын газар
АЖЦ- Ардын журамт цэрэг
АТЗГ- Ардын Түр Засгийн газар
АХЦ - Ардын хувьсгалт цэрэг
БШУЯ- Боловсрол, Шинжлэх ухааны яам
БНУ- Бүгд Найрамдах улс
БХТА -Батлан хамгаалахын төв архив
Д.- данс
ДВР- Дальне-Восточная Республика
Д.В.Сек. -Дальне-Восточный Секретариат
ДИУ- Дундад Иргэн улс
ГХАК-Гадаад хэргийн ардын комиссиарат
ГХТА-Гадаад харилцааны төв архив
ЗОУ- Зөвлөлт Орос улс
ЗСБНХОУ- Зөвлөлт социалист Бүгд Найрамдах Холсбоот Орос улс
ИМБТ СО РАН, ЦВРК- Институт монголоведения, буддологии и тибетологии Сибирского Отделения Российской Академии наук, Центр восточных рукописей и ксилографов
МАН -Монгол Ардын нам
МУУТА – Монгол Улсын Үндэсний төв архив
НАРБ- Национальный архив Республики Бурятия
НАРК -Национальный архив Республики Калмыкия
ОК(б)Н - Оросын коммунист большевик нам
Р.В.С.Р- Революционный Военный Совет Республики
С.- Сан
ТБА – Түүхийн баримтын архив
ТУЗХ- Түүх,угсаатны зүйн хүрээлэн
УТНОНББА- Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив
Х.- хөмрөг
ХҮХ - Хосгүй үнэт хөмрөг
ХН - хадгаламжийн нэгж
ХЦЗ - Хувьсгалт цэргийн зөвлөл
ШУА - Шинжлэх ухааны Академи
ШУА.ТУЗХ. ССБМТ-ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт, мэдээллийн төв

ХУРААНГУЙ

Хамтарсан төслийн Монголын талын судалгааны ажил ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Ойрхи үеийн түүхийн салбарт төвлөн, түүхч мэргэжлийн 4 судлаач оролцон гүйцэтгэв.

Монголын талын гүйцэтгэгчид нь нэгд, 1921 оны хувьсгалын түүхийн судалгааны төлөв байдлыг тодорхойлох, хоёрт, эх сурвалж, мэдээллийн санг өргөтгөх, шинээр илрүүлсэн баримт материалыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, гуравт, Монголын 1920-1921 оны хэрэг явдал, 1921 оны хувьсгалд оролцогчдын судалгааг гүнзгийрүүлж, шинэ нэрсийг олж тогтоох, монгол үндэстний төлөөлөгчдийн оролцоог тодруулах, тэдний үйл ажиллагааг нэхэн сэргээх, дөрөвт, Монголын 1921 оны хувьсгалын зорилго, шинж чанар, цар хүрээ, ач холбогдлыг олон талаас харж үнэлэх боломжийг бүрдүүлэхэд тус нэмэр болох бүтээлүүдийг туурвихад төслийн судалгааг чиглүүлж, хамтран ажилласны дүнд

1. Монгол улсын төрийн 4 архив / УТА-ын Түүхийн баримтын архив, УТНОНББА, БХТА, ГХТА/, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт мэдээллийн төв, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад, Халимаг улсын архиваас 1919-1922 онд холбогдох 250 гаруй баримтыг судалж, 140-ийг хуулбарлан авсан,

2. Монголын 1921 оны хувьсгалын судлагдсан байдлыг 1920 оны дундаас улируулан үзэж, монгол хэлээр дээрхи Ном зүйг бүрдүүлж, хамтын бүтээлийн 2-р хэсэг болгон хэвлүүлэв.

3. Эх баримтын ба түүх бичлэгийн судалгааны дүнд нэгэн сэдэвт 2 хамтын хамтын бүтээлд оролцож, баримт бичгийн эмхэтгэл 1, хурлын эмхэтгэл 1, эрдэм шинжилгээний өгүүлэл 5-ийг хэвлүүлж, дотоод гадаадын эрдэм шинжилгээний хуралд 7 илтгэл хэлэлцүүлэв.

4. 1921 оны хувьсгалын 100 жилийн ойд зориулсан “Ардын хувьсгал -100 жил: түүх ба орчин үе” Олон улсын эрдэм шинжилгээний зохион байгуулав.

Түлхүүр үг: Монголын 1921 оны хувьсгал, баримт, түүх, Зөвлөлт Орос улс, монгол үндэстний төлөөлөгчид, буриад, халимаг

**“1921 оны Монголын хувьсгалыг
монгол үндэстний түүхийн үүднээс харах нь”**

(1921 оны Монголын хувьсгалын 100 жилийн ойд зориулав)
Хамтарсан төслийн тайлан
(2019-2022 он)

Удиртгал

Хамтарсан төслийг хэрэгжүүлэх үндэслэл нь: Монголын төрөөс үндэсний аюулгүй байдал, шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын баримт бичгүүдийн

1.“Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6, 3.1.4-т “...үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, ...судлах ажлыг дэмжих”;

2.“Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого” баримт бичгийн 3.1-д “...улс орны хөгжилд чухал ач холбогдол бүхий шинжлэх ухааны суурь судалгааг хөгжүүлэх”;

3.“Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний 3.4.V-д “... монголчуудын эх хэл, түүх, утга зохиол, урлаг, гүн ухаан, угсаа гарал, зан заншил, уламжлал, аж төрөх хэв маягийн судалгаа нь нийгэм, хүмүүнлэгийн ухааны тэргүүлэх чиглэл байх”;

4.“Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.4.3-т “... монгол үндэстний гарал үүсэл, түүх соёлыг дэлхий дахинд сурталчлах, үнэн зөв мэдээлэл өгөх” заалтууд болон Шинжлэх ухааны Академи,Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөний зорилтуудаар тодорхойлогдсон болно.

Монголын 1921 оны хувьсгалын талаар өнөөгийн монголчуудын ойлголт, үнэлгээ харилцан адилгүй, зарим талаар ач холбогдлыг үгүйсгэх хандлага буй нь түүхэн үйл явдлыг өмнөх судалгааны өв, шинээр илрүүлсэн эх баримтад тулгуурлан илүү өргөн хүрээнд авч үзэж агуулга, сэдвийг өргөжүүлэн судлах, нийгмийн гишүүдэд шинэ мэдлэг өгөх, гүнзгийрүүлэн тайлбарлах шинжлэх ухаан, нийгмийн хэрэгцээ шаардлагыг бий болгосон. Түүнчлэн түүхэн үйл явдлын 100 жилийн ойд зориулсан ном бүтээл гаргах бүтээл гаргах зорилтыг тавьж хамтарсан төслийг хэрэгжүүлсэн болно.

Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, будд, төвд судлалын хүрээлэнтэй хамтран “1921 оны Монголын хувьсгалыг монгол үндэсний түүхийн

үүднээс харах нь” (1921 оны Монголын хувьсгалын 100 жилийн ойд зориулав) эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх асуудлыг Түүх, археологийн хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн 2019 оны 3 сарын 6-ны өдрийн хурлын 2 дугаар хурлаар хэлэлцэж дэмжсэн. Дэвшүүлсэн төсөл Оросын суурь судалгааны сан ба Монгол улсын БСШУСЯ-аас зарласан “Суурь судалгааны шилдэг төслүүд (Монг_т)” шалгарч, БСШУС-ын сайдын 2019 оны 10дугаар сарын 07-ны өдрийн А/622 тоот тушаалаар батлагдаж, төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх ШУГх/ОХУ/-2019/10/ дугаартай гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан болно.

Төслийн зорилго: нь Монголын 1921 оны хувьсгалын түүхийн судалгааны агуулга, сэдэв, хүрээг тэлэх, эх сурвалж, мэдээллийн санг баяжуулах шинжлэх ухаан, нийгмийн хэрэгцээ шаардлагыг үндэс болгон

а/1921 оны хувьсгалын түүхийн талаар эрдэм шинжилгээний ном бүтээл туурвих,

б/100 жилийн ойд зориулсан олон улсын хурлыг зохион байгуулж олон нийтэд сурталчлах,

в/төслийн судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн хэлбэрээр гадаад, дотоодын хүргэж танилцуулахад орших бөгөөд 1921 оны хувьсгалын 100 жилийн ойд зориулагдана.

Төслийн санхүүжилт: Батлагдсан санхүүжилт: 36.000,000 төгрөг,

Олгосон санхүүжилт: 32.640.000 төгрөг.Үүнд:

2019 он: санхүүжилт олгогдоогүй.

2020 он:12,000,000 төг

2021 он: 8,640,000.000 төгрөг,

2022 он:12,000.000төгрөгийг судалгааны зардалд тус тус авч зориулалтын дагуу зарцуулав. Санхүүгийн тайланг тусад нь гаргаж, ШУИС-аар хянуулж, тушаасан. Гүйцэтгэлийн дүн: 27,165.531 төг .

Хамтарсан төслийн ажлын зохион байгуулалт: Төслийн судалгааг “Календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу явуулах үүргийг төслийн удирдагч хүлээж, явц, гүйцэтгэлд хүрээлэнгийн захиргаа хяналт тавьж ажиллав. Үүнд:

а/Төслийн хурлыг жил бүр 3-4 удаа хийж “Календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу гүйцэтгэх ажлыг нарийвчлан тогтоох, нэмэлт оруулах, судалгааны үе шат

бүрийн зорилтыг хамтрагч Оросын талын гүйцэтгэгчидтэй хамтран хэлэлцэх, тус бүрийн хариуцсан ажлын явц үр дүнг мэдээлэх, Монгол улс ба ОХУ-ын төрийн ба БНУ-ын архивуудад эрдэм шинжилгээний томилолтоор ажиллаж баримт илрүүлэн судлах, хуулбарлах, төслийн судалгаагаар бичих нэгэн сэдэвт хамтын бүтээл, Номзүйн бүтээлд Монголын талаас материал бэлтгэх, орчуулах, бүлэг зүйлийг бичих, баримтын эмхэтгэлийг монгол, орос хэлний баримтаар бүрдүүлэх, хамтын бүтээлийг зохиогчдын зөвлөлгөөнөөр хэлэлцэх, редакторлах, хэвлэн нийтлэх, судалгааны явц, гүйцэтгэлийг тайлагнах зэргээр ажиллав.

б/ Хамтарсан төслийн Монголын талын судалгааны баг нь ажлын тайланг хагас, бүтэн жилээр бичиж, гүйцэтгэгч байгууллага-ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн “Эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны тайлан”-д тусгаж ирэв.

в/Төслийг хэрэгжүүлэх хугацаанд санхүүжүүлэгч байгууллага - ШУТС-нд 4 удаа тайлан өгөв.

“1921 оны Монголын хувьсгалыг монгол үндэсний түүхийн үүднээс харах нь” (1921 оны Монголын хувьсгалын 100 жилийн ойд зориулав)

Хамтарсан төслийн Үр дүнгийн тайлан

Төслийн судалгаа “Календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу явагдаж ирснийг он оноор харуулбал:

2019 он: төслийн санхүүжилт өгөгдөөгүй боловч төслийг эхлүүлж, “Календарчилсан төлөвлөгөө”-нд заасан

1.Төслийн судалгааны төлөвлөгөө, сэдвийн судлагдахууны хүрээ, заагийг хамтрагч талтай хэлэлцэж, нарийвчлан тогтоох,

2.Судалгааны ном бүтээлийн цэсийг гаргах/ 0,5х.х./,

3.Монгол улсын ҮТА-ын УТНОНББА, БХТА, ОХУ-ын Халимагийн Үндэсний архив, Халимагийн Шинжлэх ухааны төвийн архив, номын сангаас судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулах, эх баримтыг монгол бичгээс кирилл үсэгт буулгах /4-5 х.х./,

4. Эрдэм шинжилгээний 1 өгүүлэл бичих,

5.Төслийн эхний жилийн гүйцэтгэлийн тайлан бичих ажлууд тусгагдсан болно.

Гүйцэтгэл:

1.**Сэдвийн судалгааны номзүйн цэс үйлдэх ажлын дагуу:** 1921 оны хувьсгалын түүхийн сэдвээр Монгол улсад гарсан ном бүтээлийг бүртгэлийг гаргах ажлыг эхэлж, судалгааны явцад Номзүйн цэсийг өргөтгөн, “1921 оны Монголын хувьсгалын ном зүй” хамтын бүтээлийг орос, монгол хэлээр гаргахаар хамтрагч талтай тохиролцож, дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

а/Төслийн гүйцэтгэгч Ч.Батдорж: хамтын бүтээл болон нэгэн сэдэвт зохиол 40, диссертаци 10, баримт бичгийн эмхэтгэл 20, ном товхимол, өгүүллийн эмхтгэл 100, эрдэм шинжилгээний өгүүлэл 200 гаруйг бүртгэв / 40 хуудас /.

б/Төслийн гүйцэтгэгч Н.Наранжаргал: “Монгол ардын хувьсгалын тухай ном өгүүллэгүүдийн тайлбартай бүртгэл (1921–1967 он)/ Эмхт. Д.Данзан., Д. Бүрэндалай., Г.Пүрэвдорж; Ред. Б.Банзрагч. УБ.,1970/ -ээс сэдвийн дагуу 500-аад бүтээлийн жагсаалтыг /29 хуудас/ шивж ашиглахад бэлэн болгов.

в/Төслийн удирдагч Н.Хишигт: хамтын бүтээл болон нэгэн сэдэвт зохиол 40, диссертаци 10, баримт бичгийн эмхэтгэл 20, ном товхимол, өгүүллийн эмхтгэл 100, эрдэм шинжилгээний өгүүлэл 200 гаруйг бүртгэв/ 40 хуудас /.

Эдгээрийн үндсэн дээр “1921 оны Монголын хувьсгалын тухай ном зүй” хамтын бүтээлийн “II анги. Монгол хэл дээрхи ном бүтээлүүд” хэсэгт орох бүтээлүүдийн номзүйн бүртгэл/110 хуудас/-ийг стандартын дагуу үйлдэж, урьдчилсан байдлаар хамтрагч талд танилцуулж, Оросын талын судлаачдын үйлдсэн номзүйн бүртгэл /115 хуудас/-ийг хүлээн авав.

2.Баримт материал илрүүлэх,судлах хүрээнд :Монгол улсын ҮТА-ын УТНОНББА, ШУА-ийн ТУЗХ-ийн Сурвалж судлал,баримт мэдээллийн төвийн сан хөмрөг, ОХУ-ын Халимаг улсын Үндэсний архив, Халимагийн Эрдэм шинжилгээний төвийн архив, Номын сан, Санкт-Петербург хотын Оросын ШУА-ийн архив зэрэг газруудад хадгалагдаж буй баримтуудыг судалж, жагсаалт үйлдэх, заримыг хуулбарлан авах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

а/Төслийн гүйцэтгэгч Ч.Батдорж: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж бичиг, баримт мэдээллийн төвийн сан хөмрөгөөс 1921 оны хувьсгалын түүхэнд холбогдох 44 баримтын жагсаалт үйлдэв /4 хуудас/.

б/Төслийн гүйцэтгэгч Ш.Эрдэнэбат: ҮТА-ын Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архивын сан хөмрөгөөс баримт илрүүлэх ажлыг хийж, “МАН,1921 оны хувьсгалын түүхэнд холбогдох хосгүй үнэт баримтын жагсаалт” /26 баримт, 3 хуудас/-ыг үйлдэж, монгол бичгээс кирилл үсэгт хөрвүүлэх ажлыг эхлэв.

в/Төслийн гэрээт гүйцэтгэгч Н.Наранжаргал: Докторантурт сурах хугацаанд Халимагийн Үндэсний архиваас илрүүлж судалсан баримт /30 баримт/ -ын жагсаалт үйлдэж, заримыг боловсруулах ажлыг хийж байна.

г/Төслийн удирдагч Н.Хишигт: 2019 онд эрдэм шинжилгээний томилолтоор ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг улсын Үндэсний архивт ажиллаж, 1921 оны хувьсгалд оролцсон цэргийн сургагч нарт холбогдох 16 баримтыг /34 хуудас/ баталгаат хуулбараар авч, 8 хуудас тэмдэглэл үйлдэв.

-Оросын ШУА-ийн Халимгийн шинжлэх ухааны төвийн архивт буй материалыг судалж Ц.Д.Номинханов, Х.Б.Кануков, В.А.Хомутников нарын тухай өгүүлэл, гэрэл зургийг хуулбарлан авав./1.5 х.х./

-Санкт-Петербург хот дахь Оросын ШУА-ийн архивын сан хөмрөгөөс 1920-иод оны Монголын түүх, 1921 оны хувьсгалд оролцсон орос, буриад, халимгийн зүтгэлтнүүдэд холбогдох баримт, материал хадгалагдаж буй эсэхийг дансаар шүүж, ном бүтээлийн цэс үйлдэв /5 хууд/.

3. Судалгааны үр дүнгээр өгүүлэл бичих зорилтын хүрээнд:

Төслийн удирдагч Н.Хишигт Оросын талын судлаачидтай хамтран хоёр өгүүлэл хэвлүүлэв.

2021 он: Гэрээний дагуу 2021 оны 12 сарын 18-нд 8,640.000 төгрөгийн санхүүжилт олгогдож, “Төслийн үр дүнгийн даалгавар”-т тусгагдсан дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

1.1921 оны Монголын хувьсгалын судалгааны төлөв байдлыг тогтоох тулгуур эх хэрэглэгдэхүүний суурь санг бий болгох зорилгоор Номзүйн бүтээл хийхээр судалгааны явцад тохиролцсоны дагуу “Монгол хэл дээрхи ном бүтээлүүд” номзүйн бүртгэлийг өмнөх үг, тайлбарын хамт бэлтгэн Оросын талд шилжүүлж, хамтын бүтээлийн хяналтын уншилт, редакцийг хийж, ОХУ-д хэвлүүлэв.

2.“Календарчилсан төлөвлөгөө” ёсоор “Төслийн үр дүнгийн даалгавар”-ын 2-т тусгагдсан“1921 оны Монголын хувьсгалын түүхэнд холбогдох баримт бичгүүд” баримтын эмхтгэлд Монгол улс, ОХУ-ын архиваас материал нэмэн цуглуулах ажлыг гүйцэтгэх ёстой байсан ч, дэлхий нийтийг хамарсан цар тахлын үеийн хилийн хорио, гадаад томилолтын зардал хасагдсан зэрэг шалтгааны улмаас ОХУ-ын Буриад улсын Төв архив ажиллах боломж олдоогүй болно.

Баримт материалыг Монгол улсын ҮТА-ын Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архиваас голлон бүрдүүлж, хамтрагч байгууллага - Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, төвд, буддын судлалын хүрээлэнгийн Баримтын төвөөс 2 баримтыг хуулбараар захиалж авав. Нийт 400-аад баримтын жагсаалт гаргаснаас 250 баримтыг сонгож, хуулбарлан авах, монгол бичгээс хөрвүүлэх, тайлбар бичих ажлыг эхлүүлэв. Уг эмхэтгэлийг 2022 онд хэвлүүлэхээр

“Соёмбо принтинг” ХХК-тай хэвлэлийн гэрээг байгуулж, 2021 оны санхүүжилтээс зардлыг шилжүүлэв.

3.Хамтарсан төслийн “Үр дүнгийн даалгавар”-ын 3-т тусгагдсан “Монголын хувьсгал-100 жил” олон улсын хурлыг зохион байгуулах ажлыг дараах байдлаар гүйцэтгэв.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 сарын 30-ны өдрийн “Ой тэмдэглэх тухай” 250 дугаар тогтоолыг үндэслэн, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 сарын 19-ний өдрийн А/125 тоот тушаалаар байгуулсан ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д.Рэгдэлийн ахалсан Ажлын хэсэгт хамтарсан төслийг хэрэгжүүлэгч Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, төслийн Монголын талын удирдагч Н.Хишигт нар оролцож хурлын гол зохион байгуулагчаар ажиллав. Үүнд:

а/Бэлтгэл ажил:-ыг зохион байгуулж, олон улсын хурлын зарыг ШУА, хүрээлэн, ОУМСХ-ны сайтад (Эх сурвалж:<https://history.ac.mn /c/1011348? content=1981214>) байршуулан, гадаад дотоодын эрдэмтдэд хүргэж, оролцох хүсэлт, илтгэлийн товчлол,илтгэл, бичлэгийг хүлээн авч, эмхтгэхэд бэлтгэх ажлыг гүйцэтгэв.

б/1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын 100 жилийн ойд зориулсан улсын хэмжээний уг хурлыг 2021 оны 12 сарын 9-нд Монгол улсын Улаанбаатар хотноо, Төрийн ордонд хийж Монгол улс, ОХУ, БНЭУ, Япон улсын эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, архив, музей зэрэг 18 байгууллагын эрдэмтэн судлаачид нийт 30 илтгэл хэлэлцүүлэв. Цар тахлын нөхцөл байдлаас хамааран гадаадын эрдэмтэд Онлайнаар болон видео-бичлэгээр танилцуулав.

Нээлтийн хуралдаан:-ыг ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл нээж, Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн мэндчилгээ, УИХ-ын гишүүн, БШУ-ны сайд Л.Энх-Амгалан нарын мэндчилгээг танилцуулж 3 үндсэн илтгэлийг сонсов.

“1921 оны Монголын хувьсгалын өрнөл, ялалт, ач холбогдол” нэгдүгээр салбар хуралдаанд: ХХ зууны эхэн үеийн бүс нутгийн улс хоорондын харилцаанд Монголын эзлэх байр суурь, статус, хаант Монгол улсын түүхийн зарим асуудал, 1920-1921 оны хэрэг явдлууд, нууц бүлгүүд, улс төрийн хүчнүүдийн төлөөлөгчдийн ЗОУ-дахь үйл ажиллагаа, хувьсгалын гэрч, оролцогчид, зэвсэгт хүчний асуудлыг шинжлэн судалсан илтгэлүүдийг хэлэлцэж санал солилцов.

“ХХ зууны Монгол улсын нийгэм, улс төр, оюун санааны амьдрал” хоёрдахь салбар хуралдаанд: монголчуудын үзэл санааны уламжлал, 1921 оны хувьсгалын үндэсний ба гадаадын түүх бичлэг, эх сурвалжийн судалгаа, Ардын Засгийнгазраас нийгмийн амьдралын олон салбарт авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэсэн илтгэлүүдийг танилцуулав.

Салбар хуралдаанаар хэлэлцсэн илтгэлүүд нь ХХ зууны эхэн үеийн Монголын улс төрийн үйл явдлуудын талаар сонирхолтой тайлбар, үнэлэлт дүгнэлт өгсөн, гадаад, дотоодын архив, музей, эрдэм шинжилгээний байгууллагад хадгалагдаж байгаа түүхэн баримт, гэрэл зураг зэрэг судалгааны олон төрлийн эх хэрэглэгдэхүүнийг танилцуулсанаараа онцлог болохын дээр, 1921 оны хувьсгалын түүхийн судалгааны сэдэв өргөжүүлж, эх сурвалж, мэдээллийн санг баяжуулсаныг тэмдэглэх нь зүйтэй.

Хаалтын нэгдсэн хуралдаанд: салбар хуралдаануудын дүнг танилцуулж, цаашид сэдвийн судалгааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх талаар санал солилцов. Бүхэлдээ, олон улсын эрдэм шинжилгээний хурал нь Монголын түүхийн гарамгай үйл явдлуудын нэг 1921 оны хувьсгалын түүхийн судалгааны салбарт ажиллаж буй дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл туурвил, судалгааны шинэ сонин үр дүнтэй танилцах, баримт, эх хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний эргэлтэд шинээр оруулах, дэлхийн улс орнуудад хадгалагдаж буй баримт материалыг судлах, хэвлэн нийтлэх, сэдвийн судалгааны салбарт хамтран ажиллаж ирсэн уламжлалыг сэргээх талаар санал солилцох зорилгоо бүрэн биелүүлэв.

Тус хуралд хамтарсан төслийн Монголын талын гүйцэтгэгчдээс 3, Оросын талын гүйцэтгэгчээс 2 судлаач, 4 илтгэл хэлэлцүүлэв

2022 он:12,000.000 төгрөгийн санхүүжилт авч,“Календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу дараах ажлыг гүйцэтгэв.Үүнд:

1.Хамтарсан төслийн “Үр дүнгийн даалгавар”-ын 1-д заасан Оросын талын эрхэлсэн хамтын бүтээлд “Монголын түүх бичлэг дэх О.И.Макстенек” 1-р бүлгийг бичиж, ном зүйн жагсаалт, холбогдох эх баримт, эрдэм шинжилгээний тайлбарын хамт бүрэн шилжүүлэв. /Нийт 45 хуудас/. Дээрхи материалаас 36 хуудас материалыг монгол хэлнээс орос хэлнээ орчуулсан болно /Эрдэм шинжилгээний орчуулгыг

хүлээн авсан тухай Оросын талын удирдагчийн тодорхойлолт буй/. Уг хамтын бүтээл 2022 онд хэвлэгдэв.

2.“Төслийн үр дүнгийн даалгавар”-ын 2-т тусгагдсан “1921 оны Монголын хувьсгалын түүхэнд холбогдох баримт бичгүүд” баримтын эмхтгэлийг бэлтгэж, хэвлэлд шилжүүлэх төлөвлөгөөний дагуу:

а/Монгол улсын Үндэсний төв архив болон Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архиваас 136 хуудас баримтыг скан хуулбараар авав.

б/Монгол улсын Батлан хамгаалахын Төв архив, Гадаад харилцааны төв архиваас баримт нэмэн илрүүлж цуглуулан боловсруулалтыг хийв.

Өмнөх онуудын судалгаагаар авсан баримтуудын сонголтыг дахин нягталж, агуулгын хувьд эмхтгэлд зайлшгүй орох шаардлагатай баримтуудыг өмнө хэвлэгдсэн баримтын эмхтгэлүүдээс авч бичих, эх баримт нь буй эсэхийг шалгаж нягтлах, архивзүйн бүрдүүлэлт үйлдэх ажлыг дуусгав. / Нийт 170 хуудас/.

в/Харин Удиртгал, эрдэм шинжилгээний тайлбар бичих, хүний ба газарзүйн нэрийн жагсаалт үйлдэх ажлыг бүрэн дуусаагүй тул эмхэтгэлийг 2022 онд багтаан хэвлүүлж хараахан чадаагүй болно.

*Тайлбар:*1921 оны хувьсгалын түүхийн баримт бичгийн тусгайлсан эмхтгэл 1971, 1980 оноос хойш гараагүй удсан нөхцөлд эмхтгэлийг боломжийн хэрээр чанартай гаргахын тулд баримтыг анхдагч эхээр нь илрүүлэх, зураг хэлбэрээр хэвлэлийн шаардлагад нийцүүлсэн хуулбар хийх, бичвэр хөрвүүлгийг боловсруулах, баримтыг хасаж таналгүй бүрэн эхээр нь оруулах, зүүлт тайлбарыг шинэ мэдлэгийн төвшинд үйлдэх зэрэг нь цаг хугацаа, судалгаа, техник боловсруулалт шаардаж байгаатай холбоотой болно.

Эмхэтгэлд нийт 136 баримтын бичвэр хөрвүүлэг, эрдэм шинжилгээний тайлбар болон шинээр илрүүлсэн баримтуудаас 60-70 баримтыг зургаар татаж оруулахаар бэлтгэв.

3.Хамтарсан төслийн ажлын уулзалт, зөвлөлгөөнийг 2022 оны 6 сарын 27-оос 7 сарын 6-ны хооронд ОХУ-ын БНБуриад улсын Улаан-Үд хотноо зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, төслийн Монголын талын удирдагч Н.Хишигт


а/ эрдэм шинжилгээний хамтарсан төслийн явц, гүйцэтгэлийг танилцуулах,

б/Оросын талын гүйцэтгэж буй хамтын бүтээлийн хэлэлцүүлэг, хяналтын уншилт, редакци хийх,

в/Монгол, будд, төвд судлалын хүрээлэнгийн гар бичмэлийн санд ажиллаж, “Монголын 1921 оны хувьсгалын түүхэнд холбогдох баримт бичгүүд” эмхтгэлд оруулах баримт судлах ажлыг гүйцэтгэв.

“1921оны Монголын хувьсгалыг монгол үндэсний түүхийн үүднээс харах нь” (1921 оны Монголын хувьсгалын 100 жилийн ойд зориулав) Монгол, Оросын хамтарсан төслийн “Үр дүнгийн даалгавар”-т 5 ажил тусгагдсаныг судалгааны баг биелүүлсэн хэмээн үзэж байна.

Хамтарсан төслийн судалгааны үр дүнд туурвисан бүтээлүүдийн агуулга, шинэлэг тал, ач холбогдлыг тус бүрээр товч тодорхойлбол:



Библиография Монгольской революции 1921 года/ “1921 оны Монголын хувьсгалын ном зүй”. (Отв.ред:Л.В.Курас,Н.Хишигт; науч. ред: С.В. Васильева, Б.Тунгалаг; Сост: Л.В. Курас, Н. Хишигт, Б.Д. Цыбенков,Ч.Батдорж, Н.Наранжаргал, Ц.С. Очиров).Улан-Үдэ-УБ: Оттиск, 2021. 320 с

ISBN 978-5-6045840-4-0

Номзүйн бүтээл нь: Удиртгал, үндсэн 2 анги, Хүний ба газар зүйн нэрийн хэлхээнээс бүрдэнэ.

Орос, монгол хэлээр хэвлэгдсэн энэхүү Ном зүйн бүтээлд: номзүйн лавлагаа,эрдмийн зэрэг горилсон бүтээл, баримт бичгийн эмхэтгэл, нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэвтэрхий толь зэрэг 6 төрөлд хамаарах нийт **2687** ном бүтээллийн мэдэллийг “Орос хэл дээрхи бүтээлүүд”, “Монгол хэл дээрхи бүтээлүүд”() хэмээх 2 хэсэгт хувааж, Номзүйн ангиллын дагуу цагаан толгойн үсгийн дарааллаар бүртгэж тодорхойлолтыг үйлдэв. Үүнд: орос хэл дээрхи 825, монгол хэл дээрхи1862 бүтээл багтсан болно.

1921 оны хувьсгалын ном зүйн сэдэвчилсэн эмхтгэл Монгол улсад 1970 оноос хойш гараагүй, ОХУ-д энэ ажил огт хийгдээгүй өнөөг хүрсэн үед Номзүйн дэлгэрэнгүй лавлагааг гаргасан нь

нэгд, Монголын 1921 оны хувьсгалын түүхийн асуудлаар Монгол улс, ОХУ-д 1920-иод оны дундаас 2021 он хүртэл гарсан ном бүтээлийн талаархи мэдээллийг боломжийн хэрээр нэгтгэж, дэлгэрэнгүй бүртгэл хийсэн;

хоёрт, Номзүйн сэдэвчилсэн бүртгэлийг анх удаа монгол, орос хэлээр хавсран гаргасанд шинэлэг тал нь оршино.


Бүтээлийн *шинжлэх ухаан, практикийн ач холбогдол*:-ыг

1. Номзүйн дэлгэрэнгүй лавлагаа болохын хувьд сэдвийн судалгаанд ашиглах, тулгуурлах мэдээллийн санг баяжуулсан,

2., төслийн судалгааны үр өгөөж, хэрэглээг нэмэгдүүлсэн,

3. монгол, орос хоёр хэлээр хавсран хийгдсэн анхны сэдэвчилсэн бүртгэл болохын хувьд сэдвийн судалгааны төвшинг үнэлж, цаашдын зорилт, чиглэл, сэдвийг тодорхойлон судлахад тулгуур болох мэдээллийн эх булаг болж буйгаараа онцлог ач холбогдолтой юм.

Нэгэн сэдэвт хамтын бүтээл:



Л.В.Курас, Н.Хишигт, Б.Д.Цыбенон. *Забыйтый дипломат: Отто Иванович Макстенок – первый уполномоченный Советской России в Монголии. К 100-летию Монгольской революции 1921 г.* /Науч. ред. Б.В. Базаров. Ирк: “Оттиск”, 2022. – 184 с.

ISBN 978-5-6047699-6-6

Хамтын бүтээл нь Удиртгал, 4 бүлэг / 24 зүйл/, Төгсгөл, Ном зүй, Хавсралтаас бүрдэнэ.

Удиртгалд: Монголын 1921 оны хувьсгалын бэлтгэл ажлын үед ЗСБНХОУ-ын Гадаад хэргийн Ардын комиссиаратаас Монголд томилогдсон анхны бүрэн эрхт төлөөлөгч О.И.Макстенекийн намтар үйл ажиллагаа Монголын болон Оросын түүх

бичлэгт хэрхэн тусгагдсан болон Монгол улс ба ОХУ-ын төрийн архивуудаас илрүүлэн судалсан үндсэн эх сурвалжийг задлан шинжлэв.

Нэгдүгээр бүлэгт: О.И.Макстенекийн идэр нас, Латви дахь үйл хэрэг,

Хоёрдугаар бүлэгт, Улс төрийн цөллөгт байсан үе, Эрхүү мужид ирсэн, 1917 он, Оросын Иргэний дайны үеийн үйл явдлууд,

Гуравдугаар бүлэгт, Дорно зүгийн орнуудын талаархи ЗОУ-ын бодлого, МАН байгуулагдсан, хувьсгалын бэлтгэл ажил, зэвсэгт хүчийг бүрдүүлсэн үйл явцын дэвсгэр дээр бүрэн эрхт төлөөлөгчийн улс төр, дипломатын үйл ажиллагаа,

Дөрөвдүгээрт бүлэгт: Иргэний дайны дараа үеийн О.И.Макстенекийн ажил хэрэг, БНМАУ-ын төрийн дээд шагналаар шагнагдсан, 1930-аад онд ЗХУ-д “Латышийн үндэсний төвийн хэрэг” гэгчид холбогдуулан хэлмэгдүүлсэн талаар өгүүлж, үйл ажиллагааг үнэлж дүгнэв.

Төгсгөлийн оронд: О.И.Макстенекийн судалгааны үр дүн, гаргасан ном өгүүллүүдийг олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад танилцуулсан талаар, Хиагт хотноо Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгчийн байрлаж байсан байр буюу эдүгээ Орос-Монголын найрамдлын музейд хадгалагдаж буй Монголын 1921 оны хувьсгал, О.И.Макстенект холбогдох үзмэрүүдийг шинэчлэн дэглэх санал гаргасныг дурдав.

*Номын хавсралт №1-7:-*д О.И.Макстенекийн намтар, Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан шийтгэсэн материал, МАЗТГ-ын хурлын протокол, БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 7 сарын 18-ны өдрийн хурлын тогтоол зэрэг эх баримтуудыг бүрэн эхээр болон хэсэгчлэн оруулав.

Төслийн судлаачдын Монгол улс, ОХУ, Латви улсын төрийн ба орон нутгийн, байгууллагын зэрэг 8 архивын сан хөмрөгөөс илрүүлсэн олон арван баримтын үндсэн дээр Зөвлөлийн засагт Орос улсын Гадаад хэргийн Ардын комиссиаратаас Монголд томилогдсон анхны бүрэн эрхт төлөөлөгч О.И. Макстенекийн намтар, амьдрал, үйл ажиллагааны үндсэн үеүдийг тодруулан гаргахдаа,

1921 оны Монголын хувьсгалтай холбогдох асуудалд илүүтэй анхаарал хандуулж, тэр хүрээнд эрх чөлөөний тэмцэлдээ ЗОУ-аас тусламж олохоор явсан Монголын эх орончид /“Анхны долоо”/-ийн үйл хэрэг, монгол угсаатан-буриад нарын оролцоог судалж шинэ мэдлэг бий болгохыг хичээв. Тухайлбал,

а/Монголд нэвтэрч чадалгүй Троицкосавскт сууж байсан бүрэн эрхт төлөөлөгч О.И.Макстенек ЗОУ-д одох Монголын эх орончдын хэсэг бүрийг хүлээн авч илгээх, Нийслэл Хүрээн дэх намын нөхөдтэй холбоо барих явдлыг хангах, хилийн бүс нутагт хамтран ажиллахын зэрэгцээгээр энхүү үйл ажиллагаанд монгол үндэстний нэг хэсэг - буриад нарыг татан оролцуулсаныг тодруулан судлах замаар 1921 оны хувьсгалын бэлтгэл ажил хэрхэн явагдсаныг түүхийн үүднээс нэхэн сэргээхийг оролдсон,

б/Монгол, Оросын түүх бичлэгийн дэлгэрэнгүй судалгааг хийсэн,


в/1920-1921 оны Монголын улс төр, нийгмийн байдал, хятад, цагаантны эзэрхийлэл, Монголын улс төрийн бүлгүүд, эрх баригчдын байр суурийн тухай О.И.Макстенекээс явуулж байсан илтгэл, мэдээлэл, тайлан зэрэг олон арван шинэ баримтыг судалгааны эргэлтэд оруулсан зэрэг болно.

Бүтээлийн шинжлэх ухаан, практикийн ач холбогдол:-ыг

- Хамтын бүтээлийг туурвих явцад шинээр илрүүлсэн баримтууд нь 1921 оны хувьсгалын түүхийн эх сурвалжийн болон мэдээллийн санг өргөтгөсөн;
- Монгол, Оросын түүх бичлэгт О.И.Макстенекийн тухай гарч буй анхны бүтээл болсон;
- Сэдвийн, нэн ялангуяа Монголын 1921 оны хувьсгалд оролцогчдын намтрын судалгаанд шинэ чиглэл бий болох боломжийг нээсэнд тус тус оршино.
- Энэхүү хамтын бүтээлийн талаар ОХУ-д нэг шүүмж гарсан¹.

¹Орлова К. В. «...Незаслуженно забытые герои...». Рец. на: Курас Л. В., Хишигт Н., Цыбенев Б. Д. Забытый дипломат: Отто Иванович Макстенек - первый уполномоченный Советской России в Монголии. К 100-летию Монгольской революции 1921 г. / науч. ред. Б. В. Базаров. Иркутск: Оттиск, 2022. 184с. // Монголоведение. 2022. Т.14. № 4.С. 834–838. DOI: 10.22162 /2500-1523-2022-4-834-838

Хурлын эмхэтгэл:



“1921 оны Ардын хувьсгал-100 жил: түүх ба орчин үе. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2021.11.25”.
(Эмхэт: Н.Хишигт, Ч.Батдорж, Г.Цэрэнсугар Ц.Энхжаргал).
УБ.: “Соёмбо принтинг” ХХК, 2021, 344 тал.

ISBN 978-9919-9795-3-9

Эмхэтгэлд: 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын 100 жилийн ойн олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавигдсан 30 илтгэлийг хэвлүүлэв.

Монгол улс, ОХУ, БНЭУ, Япон улсын эрдэмтэн судлаачдын хэлэлцүүлсэн эдгээр илтгэлүүд нь ХХ зууны эхэн үеийн бүс нутгийн улс хоорондын харилцаанд Монголын эзлэх байр суурь, Монголын 1991,1921 оны түүхэн үйл явдлуудын харилцан хамаарал, монголчуудын үзэл санааны уламжлал, 1921 оны хувьсгалын үндэсний ба гадаадын түүх бичлэг, эх сурвалжийн судалгаа, хаант Монгол улсын түүхийн зарим асуудал, Монголын улс төрийн бүлгүүд, ЗОУ-д очсон төлөөлөгчид, хувьсгалын зэвсэгт хүчин, АЗГ-ын бодлого, үйл ажиллагааг дүгнэсэн, хувьсгалын удирдагчид, оролцогчдын намтрын судалгааг баяжуулж, гадаад, дотоодын архив, музейд хадгалагдаж байгаа түүхэн баримт, гэрэл зураг зэрэг эх хэрэглэгдэхүүний талаар цоо шинэ мэдээллийг агуулсанаараа онцлог бөгөөд 1921 оны Монголын хувьсгалын түүхийн судалгааг өргөжүүлэхэд чиглэсэн байна

Баримтын эмхэтгэл:

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын түүхийн эх бичгийн судалгааг үргэлжлүүлж, Монгол улс /ҮТА-ын Түүхийн Баримтын Архив, Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын архив, Гадаад харилцааны төв архив, Батлан хамгаалахын төв архив, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт мэдээллийн төв/ ба ОХУ-ын төрийн архивууд /ОХУ-ын Гадаад бодлогын архив /АВПРФ/, Нийгэм улс төрийн түүхийн улсын архив /РГАСПИ/, Бүгд Найрамдах

Буриад улсын Үндэсний архив-НАРБ, Бүгд Найрамдах Халимаг улсын Үндэсний архив - НАРК/-аас 1919-1922 оны Монголын нийгэм, улс төр, 1921 оны хувьсгалын түүхэнд холбогдох 250 гаруй баримтыг илрүүлэн судалж, монгол хэл дээр 108, орос хэл дээр 28, нийт 136 баримтыг хөрвүүлэг, эрдэм шинжилгээний тайлбар, 60-70 баримтыг гэрэл зургаар оруулж эмхэтгэн хэвлэлд бэлтгэв.



“1921 оны Монголын хувьсгалын түүхэнд холбогдох баримт бичгүүд.(1919-1922 он)”. Баримтын эмхэтгэл. (Эмхэт-ред: Н.Хишигт, Л.В.Курас; Эмхэт: Ч.Батдорж, Н.Наранжаргал, Б.Д.Цыбенков, Ш.Эрдэнэбат). УБ.: “Соёмбо принтинг” ХХК., 2022. 260 тал/

ISBN:978-9919-0-0299-2

Эмхэтгэл нь Удиртгал, баримтын жагсаалт, хөрвүүлэг, гэрэл зургийн хуулбар, зарим баримтын тайлбар, Хүний ба газарзүйн нэрийн хэлхээнээс бүрдэнэ.

Нийт баримтын 70 шахам хувь шинээр илрүүлсэн, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй баримтууд бөгөөд эх зургаар нь татан оруулж, хөрвүүлгийг хамт нийтэлж байгаагаараа хувьд үнэ цэнэтэй болно.

Үүний хамт түүхэн үйл явдлын тасралтгүй шинжийг илэрхийлэх үүднээс АТЗГ, МАН, АЖЦ-ийн түүхэнд холбогдох өмнө хэвлэгдсэн зарим баримтыг бүрэн эхээр нь оруулж, урьд өмнө нь хасаж хэвлэсэн, нэр томъёог алдаж уншсан зэргийг аль болохоор залруулахыг хичээж, тайлбар үйлдэв.

5.Хамтарсан төслийн хүрээнд эрдэм шинжилгээний өгүүлэл 5-ыг хэвлүүлэв. Үүнд:

1.Н.Хишигт.,Л.В.Курас., Б.Д.Цыбенков. Дорогами надежд и ожиданий (монгольская делегация в ДВР и Советской России в 1920 г.// Известия лаборатории древних технологий. Изд-во Иркут.нац.иссл.технолог. ун-та, 2020. Т.16, № 1. с.163-175

2.Н.Хишигт.,Л.В.Курас.,Б.Д.Цыбенков. О т“революции в колчакии” до Монгольской революции 1921 г.//Иркут. ист-экон.ежегодник. Иркут.,Изд-во БГУ, 2020. с. 385-392

3.Н.Хишигт, Л.В. Курас,Б.Д.Цыбенков. О.И.Макстенек: у истоков монгольской революции 1921 года //Oriental studies. Том 13, № 2. Элиста., 2020. с. 305-317

4.Хишигт Н.,Курас Л.В., Цыбенков Б.Д. Автономная Монголия и революционная Россия: о политике Советской России в отношении Монголии в 1917-1920 гг.(к 100-летию Монгольской революции 1921 г.)//Известия Иркутского. государственного университета. Серия История.2021.Т.37.С.76–87.

5.Л.В.Курас, Б.Д.Цыбенков,Н.Хишигт.Коминтерн и Монголия в период подготовки и осуществления монгольской революции 1921 г.// Коминтерн и Восток: к 100-летию Коминтерна. М.: ИВ РАН, 2021. с. 314-324.

Төслийн судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний 7 илтгэл бичиж, гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэв.

Гадаадад:

1.Н.Хишигт.Монгольская делегация в Советской России: Переговоры в Иркутске //Монголия XX века и российско-монгольские отношения: история и экономика. Материалы междунар. науч. конф., посвящ.100-летию установления российско-монгольских дип.отношений (Россия,Иркутск, 28 мая 2021 г.). Иркут., Изд.дом БГУ. 2021. стр 7-12

2.Н.Хишигт.Монгольская революция 1921 г.:участие в ней представилей монгольского мира// “Россия и Монголия в XX-XXI вв.:к 100-летию монгольской революции и установления дип.отношений. Сборник науч.ст. /науч.ред. В.Н.Пармон, Б.В.Базаров,ред.коллегия.А.М.Плеханова [и др.].Новосибирск.:СО РАН.2021, стр.3-7

3.Н.Хишигт. Л.В. Курас, Б.Д. Цыбенков. От разведывательной деятельности к началу революционного сотрудничества: эволюция Российской политики в отношении Монголии //Всероссийская научная конференция «XXIII историко-экономические чтения, посвященные памяти Вадима Николаевича Шерстобоева» . Россия. Иркутск, 25-26 марта 2021 г.

Дотоодод

1.Ч.Батдорж.Монгол улсын Шинжлэх ухааны байгууллагаас Ардын хувьсгалын түүхийг судалж эхэлсэн нь.(1921-1945 он) //1921 оны ардын хувьсгал-100 жил:Түүх

ба орчин үе.Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл.2021 оны 11 сарын 25.(Эмхэт: Н.Хишигт,Ч.Батдорж,Г.Цэрэнсугар, Ц.Энхжаргал). УБ.: “Соёмбо принтинг” ХХК., тал16- 27

2.Н.Наранжаргал. Ардын журамт цэргийг бэхжүүлж, байнгын цэрэг байгуулах үйл хэрэгт халимаг сургагчдыг ашигласан нь //1921 оны ардын хувьсгал-100 жил: Түүх ба орчин үе. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ.:“Соёмбо принтинг” ХХК., тал 173-181

3.Н.Хишигт.1921 оны Монголын хувьсгалын дипломатын түүх ба С.ДАНЗАН // “Стратегийн судалгаа” сэтгүүл. Тусгай дугаар. 2021он.1 сар. №04. т.16-27

4.Н.Хишигт.Монголын түүх судлал дахь 1921 оны хувьсгал //1921 оны ардын хувьсгал -100 жил: Түүх ба орчин үе. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ.:“Соёмбо принтинг” ХХК., тал 16- 27